

## ЧИНГИСИЙН ОНГОНЫ ТАХИЛГЫН ГАЗРЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ

*Д.Сурнаа, доктор, ӨМИС*

**Abstract:** The eight white house of Chinggis Khaan is also named the Mausoleum of Chinggis Khaan, which is located at the Ezen Khoroo Banner of Ordos city, Inner Mongolia, and had been built from the age of Mongol Empire. Chinggis Khaan passed away during his attack and occupation of Western Xia regime, and the cart that carry his remains got trapped on its way back to Mongolian homeland around Ordos region. His people buried Chinggis Khaan's Ger, robe and one sock in this place with the service of a special ceremony. Then the cart was able to move and continue its journey to the north. From this time on, these relics was regarded as the sacred things to be worshiped by all Mongolians. Mausoleum of Chinggis Khaan is a site where Mongolian's worship and pay tribute to Chinggis Khaan and his holy spirit. At this sacred place, Darkhad people have preserved this tradition for a long time, from generation to generation to the present day. In this paper, this unique memorial service which is the core part of Mongolian's traditional ritual has been discussed.

**Түлхүүр үг:** Чингисийн онгон, тахилгын газар (байршил), ордон, тахилгын газрын өөрчлөлт, тахилгын арга хэлбэр, төв хүрээлэн, тахилгын газрын хөгжил.

Чингис хааны онгоны тахилгыг төрийн тахилгын хувиар Их Монгол улсын үед хийж эхэлсэн бөгөөд Их Юань улс, Мин улсын үед уламжлагдан үргэлжилсээр Монгол төрийн хамгийн хүндэт ёслол болж, найман цагаан ордон нь Монгол туургатны ерөнхий шүтээн болов. XVII зууны эхэн үед Монголын төр Манжийн эрхшээлд орсноос хойш, Чингис хааны тахилга нь төрийн тахилга биш болсон боловч үндэстний тахилгын хувиар өнөөг хүртэл уламжлагдаж иржээ. Одоогийн Чингис хааны тахилга бол түүхэн дэх төрийн тахилгын үргэлжлэл залгамж халаа нь юм.

Чингис хааны тахилгын газар нь одоогийн ӨМӨЗО-ны Ордос хотын Эзэн хороо хошууны Эзэн хороо багийн Баянчунхагийн талд байрлана. Чингис хааны тахилга гэдэг нь Чингис хааны онгон буюу Чингис хааны найман цагаан ордонд явагддаг тахилгыг хэлнэ. Чингис хааны тахилгын газрыг эрт дээр үед эзний цагаан гэр, найман цагаан гэр, эзний цагаан орд гэх мэтчилэн нэрлэж байгаад, XX зууны дунд ( 1956 он ) үеэс эзэн хорооны Баян Чанхагийн талд гурван бөмбөгөр

оройтой, орд харш байгуулж түүний дотор найман цагаан ордныг байрлуулан Чингисийн онгон гэж нэрлэснээс хойш одоогийн энэ нэрээрээ нэрлэгджээ.

Нийгэм, соёлын хөгжлийг дагаад, Чингис хааны тахилгын уламжлалт тахилгын арга хэлбэрт өөрчлөлт орж энэхүү тахилгын соёл нь Чингис хааны “Найман цагаан орд” хэмээх тогтмол тахилгын газартай болж, XX зууны 50-иад он болоход Монголчууд түүнийг “ Чингис хааны онгон шүтээний хүрээлэн ” хэмээн нэрийдэх болов.

### I. Чингис хааны тахилгын шүтээний нүүдэлт тахилгын арга хэлбэр

XVIII зууны эхэн үед тухайн жилийн шалтгаанаас болж Чингис хааны найман цагаан ордны доторх Чингис хааны шүтээн ордон болон сангийн шүтээн ордон нь Баян Чанхагийн голын Их эзэн хороо хошуунд байрлав. Бусад шүтээн ордон нь Ордосын хошуудад төвлөрөн тахигдаж, онцлог зарим шүтээнүүдийг хошуудын дархадууд өөрсдөө төвлөрөн сууж байгаад тэр газраа тахин шүтдэг байжээ. Эдгээр шүтээнд жил болгоны хаврын их тахилгын үеэр Их эзэн хороо цугларан ирнэ. Өөр өөр түүхэн цаг үед эзэн богд Чингис хаан болон хатадын ордоос бусад “найман цагаан орд”-ны шүтээн өөрчлөгдөж байсан боловч Чингисийн төрөөс хойш огт өөрчлөгдөлгүй одоо болтол уламжлагдаж ирсэн байна.

Чингис хааны онгон шүтээнийг тахих уламжлалт тахилга, Чингис хааны онгоныг байгуулахаас өмнө (1956 он), билгийн улирлын 3 дугаар сарын 18-ны өдөр найман цагаан ордон тахилгын газарт цуглахыг “Жийглэх” хэмээнэ. “Жийглэх гэдэг нь шатрын хөлөг гэсэн утгатай түвд үг” (Сурнаа, 2012) .

Чингис хааны тахилгын тухай зарим судалгааны бүтээлүүдэд “Жийг” гэсэн үгийг **Монгол хаад** буюу **Жинин** ноёны ордон гэр буусан найман цагаан гэр байгаа газар эсвэл туг сүлдийг тахих тахилгын газрыг заасан хэмээн тодорхойлсон байдаг. Найман цагаан ордонд жийглэж цуглах тухай тахилгын явц маш нарийн утга учиртай, ихэвчлэн “Найман цагаан орд”-ны хаврын их тахилга нь нүүдэлт тахилгын хувилбараар явагддаг байв. Чингис хааны онгон шүтээнийг тогтмол нэг газарт (**төв хүрээлэнд**)

тахих болсноос хойш Чингис хааны “Найман цагаан ордон”-д дахин жийглэж цуглан тахил хийхээ болив.

## II. Чингис хааны онгоны төв хүрээлэн

Бүгд Найрамдах Хятад Ард Улс байгуулагдсаны дараа Дархадых хамаарах байгууллагад үндсэндээ өөрчлөлт ороогүй. Засгийн газрын зөвлөлийн эрхлэгч Жинун анхнаасаа л хамааралтын үүргийг гүйцэтгэж байв. 1956 оны 5 дугаар сард Чингис хааны шинэ онгон шүтээний хүрээлэн байгуулагдлаа. Уг хүрээлэнд онгон шүтээнийг тусгайлан хамаарах байгууламжийг барьж, тусгай ажилтныг томилон, түүнд онгон шүтээнийг хамгаалж сахих, тахилга хийх ажлыг хариуцуулав. Ордос дахь хошуудаар тархаж байсан Чингис хааны найман цагаан ордон, сүлд болон Чингис хааны шүтээнүүдийг шинээр байгуулсан Чингис хааны онгонд төвлөрүүлэн тахив. Найман цагаан ордон нэг газарт төвлөрөн орших болсноос Чин улсын үед хошуу болгонд салсан найман цагаан ордон дахин нийлж, тахилганы ёс ч түүндээ зохицон өөрчлөгдөж, жийг жийглэх ёс нь түүхэн тавцангаас ухран гарсан байна.

1962 онд Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойн тахилгыг хийжээ. 1966-1976 онд соёлын хувьсгалын арван жилд Чингисийн онгоны тахилга үндсэндээ тасалдсан байдаг.

БНХАУ-ын өөрчлөлтийн дараа цаг төр тогтуун болсоноос хойш Чингис хааны тахилга, хуучин ёсоор хөгжиж иржээ.

2000 онд АААА дэсийн жуулчлалын орон болсон ба 2005 онд улсын дэсийн биет бус соёлын өвийн өвд тооцогдох бөгөөд 2011 онд ААААА дэсийн улсын хамгийн том аялал жуулчлалын орноор сонгогдсон.

Одоогоор Эзэн хороонд байгаа Чингис хааны онгон шүтээний гол тахилгын ордон нь дотроо нийт найман тахилгын ордон гэртэй. Уг найман ордонд Чингисийн онгоны тахилгын ёслолын төв өргөө, баруун талын ордонд “хур саадгийн өргөө, жолоон өргөө, бор өндөр (эсгийн хүнэг)”, гол ордонд “Чингис хаан болон Бөртэ хатны ордон, Хулан хатны ордон, Зүүн гар эзний ордон”, зүүн талын ордонд нь “Өндгөн цагааны ордон, шангийн өргөө” хамааруулна. Чингис хааны онгоны найман цагаан ордон нь гурван хатны ордон болон таван шүтээн болсон ордноос бүрдэнэ. Найман цагаан ордон нь Ордосын бүх хошуунд нэгэн адил тахигдаж байсан боловч 1954 онд түүнийг одоогийн Эзэн хороо хошууны, Эзэн хороо сумын Чингис хааны онгон шүтээний хүрээлэнд төвлөрүүлэн тахих болсон байна.

Найман цагаан ордон гэдэг нь Чингис хааны тахилгын ордоныг хүндэтгэсэн нэршил болно.

### а. Чингис хаан болон Бөртэ хатны цагаан ордон

Ордосын Чингис хааны онгон шүтээний хүрээлэнд Чингис хаан ба Бөртэ хатны цагаан ордон байрлана. Чингис хаан ба Бөртэ хатныг тахисан ордон бол өмнө хойно хоёр их чомцогийг нийлүүлж байгуулсан давхар ордон. Энэ нь өлзий хутаг орших хулийн хэлбэртэй урагш харсан орд юм. Цагаан ордныг суулгасан индэр нь хоёр давхар, доод давхар нь гурван тохой өндөр, дээд давхар нь нэг тохой өндөр, өмнө, зүүн, баруун талд нь зургаан гишгүүр шаттай, шатыг хад өрөн цохиж дээд талын давхарга дээр нь яг таарсан давхар чомцог багтсан байна. Давхар чомцогийн өндөр нь нэг жан таван тохой, халгасан дээр гуулин гандар тавьсан байна.

Цагаан ордныг тулгаар бүрж, үүд нь таван тохой өндөр, гурван тохой гаран өргөн, хоёр хаалгатай, үүдэнд нь бас бүрхүүл өлгөж байв. Давхар чомцогийн өмнөх нь араасаа тулгуур нуруугүй. Ар чомцог нь дөрвөн тулгуур таван нуруутай, үүний нэг нуруу нь давхар нуруу болно. Доор дөрвөн нурууг нь нэг жан урт, дээр давхар нуруу нь таван тохой урт байж, чомцогийн зүүн, баруун талын унь долоон тохой урт, өмнө хойд талын унь нь долоон тохой гурван ямх, дөрвөн өнцгийн унь долоон тохой зургаан ямх, ханын өндөр нь дан чомцогтой адил таван тохой, ханын модны тоо дан чомцогоос олон, ар чомцог зүүн баруун хоёр жан таван тохой, өмнө хойно гурван тохой урт байж, 100 гаруй хүнийг багтаана.

### б. Хулан хатны цагаан ордон

Хулан хатны цагаан ордон нь Чингис хаан болон Бөртэ хатны цагаан ордонтой төстэй. Өмнө хойно байрласан хул хэлбэрийн давхар цагаан ордон гэдэг нь хойно хойноосоо залгасан гэрийг хэлнэ. Хулан хатны чандарын хайрцгийг ар ордонд арц модоор дүүргэж савласан давхар тавцан дээр тавьж байв. Хайрцаг дээр нь Чингис хааны хөргийг тавин тахижээ. Тулгаар бүрсэн цагаан ордны гадна хоргой эмжээртэй, нангаар бүрж чомцогийг хоёр тохой өндөр тоосгон тавцан дээр босгожээ.

Хулан хатны чандрын хайрцагны гол хэсэгт Хангарьдын сийлбэр зураг, дөрвөн өнцөгт нь найман тахилгын сийлбэр зурагт байрлана. Хуурцагийн дотор Чингис хаан ба Хулан хатны хөргийг луу ороон зурсан байжээ. Уламжлал яриагаар энэхүү Хулан хатанг өөд болох үед

хамраас гарсан цуснаас нь авч, хөх өнгө нь чандрын үнснээс авч, бусад зүйлээр найруулан Чингис эзний хамтаар зурж тавьсан байна.

#### **в. Зүүн гарын эзний цагаан ордон**

Чингис хааны гуравдугаар хатан Есү болон дөрөвдүгээр хатан Есүгэний ордон нь Ордосын Зүүн гар хошуунд тавигдаж байсан тул Зүүн гар эзэн хэмээн дууддаг. Сүүлийн үед яригдаж байсан Хүрвэлжингуа хатны ордон гэрийг одоо Чингис хааны онгон шүтээний хүрээлэнд нийтэд нь “Зүүн гар эзэн”-ий цагаан ордон хэмээн нэрийдэх болжээ. Зүүн гар эзний ар ордонд мөнгөөр гадарлаж, алтаар өнгөлж бүрсэн Есү, Есүгэн хатны улаан зандан хайрцгийг тавьсан байна. Хайрцагт Чингис хааны ба хоёр хатны хөрөг болон нэг жижиг мөнгөн хатгуурын хамт тахиж байв. Хайрцгийн нүүрэн талд Хангарьдын сийлмэл зурагтай, дөрвөн өнцөгт нь найман тахилын сийлмэл зурагтай. Чомцогийн дотор Чингис хааны хэрэглэж байсан хоёр илд, алтан цөгц, мөнгөн бариултай гүц зэрэг алт мөнгөн сав эдлэл “Энх-Амгалангийн гуравдугаар онд дахин засварлав” гэж бичсэн “алтан бичиг”-ийг хадгалж байна.

#### **г. “Өндгөн цагаан морь” шүтээний цагаан ордон**

Одоогоор Чингис хааны найман цагаан ордонд өндгөн цагааны шүтээн гэр байдаг. Өндгөн цагааны цагаан ордонд цагаан өнгөтэй морины хөшөөг тавьж хүндэтгэн тахидаг. Өндгөн цагаан гэдэг нь үнэндээ морины зүсийг зааж байгаа юм. Монголчууд цагаан морийг хүндэтгэн үзэж тэнгэрт өргөж сэтэрлээд онгон морь болгож тавьдаг. Сэтэрлэгдэн онгологдсон энэ морио сахиусан хүлэг хэмээн, хэн ч түүнийг унах буюу алж нядалж болохгүй. Өндгөн цагаан бол Чингис хааны тэнгэр сахиусанд дээжлэн өргөсөн онгон морь юм. Одоо ч гэсэн монгол нутгийн хаана ч онголон сэтэрлэсэн морь, үхэр, ямаа байдаг.

Жил бүрийн билгийн тооллын гурван сарын хорин нэгний өдрийн цагаан сүргийн тахилгад Монголчууд өндгөн цагаанд сүсэглэн мөргөж түүнээс адис хүртдэг байна. Өндгөн цагааны тахилгад холбогддог нэг чухал үйл бол морины хөндөл дээр дүүрэн сүүтэй мөнгөн аяга тавина. Өндгөн цагаан морь хөдлөн мөнгөн аягатай сүү морины нуруун дээр асгарах үед дархад хүн морины хөдлөл байдал ба мөнгөн аяга аль зүгт хазайн унаснаар шинжинэ. Энэ бол монголчуудын морины сүүгээр төлөг үзэх онцгой нэг заншилтай холбогдоно.

#### **д. “Бор өндөр” цагаан ордон**

Бор өндөр бол Чингис хааны тэнгэрт халихад цацал өргөхөд хэрэглэсэн сүүний хөнөг юм. Бор өндрийг зандан модоор хийж гадна талаар нь гурван мөнгөн бүслүүр бүслүүлж хоёр талд нь мөнгөн матрын толгойгоос гархи зүүж сэнжилсэн байдаг. Хөнөгийн өндөр гурван тохой байх бөгөөд 150 гаруй литр сүү савладаг.

Чингис хаан амьд сэрүүн байхдаа Хэрлэн мөрний зүлгэн дээр ерэн есөн цагаагчин гүүний сүүгээр ерэн есөн тэнгэрт цацал өргөхөд бор өндөрт сүү савласан гэдэг яриа уламжлагдан иржээ. Цагаан сүргийн тахилгад ерэн есөн цагаагчин гүүний сүүг бор өндөрт савлаж ерэн есөн тэнгэрт цацал өргөдөг байв. Энд бас “ерэн есөн гүүн сүүний цацлыг дууддаг”. Одоогоор бор өндөрийн цагаан сүргийн тахилгын өдөр Чингис хааны онгон шүтээний хүрээлэнгийн зүүн талын Алтан гандар овооны дэргэд тавьдаг. Бор өндөрт сүү дүүрэн харагдаж байдаг. Энд зарим онцгой айлчин гүүний сүү өргөхөөс гадны олонх хүмүүс зах, дэглүүрээр борлуулж байгаа сүүг нэмж өргөл болгон хийдэг.

#### **е. “Жолоо” цагаан ордон**

Чингис хааны жолооны цагаан ордныг дээд жолоо, доод жолоо гэж хуваадаг. Энэ хоёр жолоог хадгалж байсан газрыг дээд жолоон хороо, доод жолоон хороо гэж нэрлэдэг. Дээд жолоо шүтээний цагаан ордонд цагаан зандан модоор сийлж, алтаар шарсан Чингис хааны онцгой хэттэй эмээл ба алтаар бүрсэн хазаар, жолоо байдаг. Энэ нь энгийн эмээлтэй адилгүй, эргүүлэгтэй сэнжтэй эмээл байв. Бас гөлөм, олом, жирэм, дарлага зэрэг зүйлс болон тахилгад хэрэглэх мөнгөн цөгц зэрэг сав байдаг. Дээд жолоонд Чингис хааны найман шарга агтны орыг сахисан нэг шарга агтны хөрөг байна. Энэ хөрөг нь найман шарга морины бэлгэ тэмдэг болдог.

#### **ё. “Хур саадаг”-ийн цагаан ордон**

Чингис хааны хур саадгийн цагаан ордон бол Чингис хааны нум сум, хоромсог зэрэг шүтээнийг тахисан шүтээний гэр юм. Мөн хур саадгийн цагаан ордныг алтан хурын цагаан ордон гэж нэрлэдэг байна. Хур саадгийн цагаан ордон дотор Чингис хааны гурван нум ба саадаг сум, хоромсгийг тахиж байна. Үүнд, богийн эврээр хийсэн нумын хөвч нь таван тохой урт байдаг. Мөн усан үхрийн эврээр хийсэн хоёр нум байдаг. Нум бүрийн хөвчийн урт нь долоон тохой. Сумыг төмрөөр, ишийг нь шар бургасаар хийж ишин

дээр нь тэсийн өдийг наажээ. Хур саадгийн цагаан ордонг Чингис хааны дархадын хүмүүс сайтар хамгаалж тахил өргөдөг. Хур саадгийн цагаан ордонд нум сумаас гадна тахилгын ном бичиг, элдэв зүйлийн алт мөнгөн сав хэрэгсэл байдаг.

*Хур саадаг нь төрийн сүлд шүтээн мөн.* “Эрдэнийн товч”-д Ойрдын Тогоон тайш хаан ширээнд суухаас өмнө найман цагаан ордонд бараалхах үедээ суманд оногдон алагдсан тэмдэглэл байдаг. Тэрхүү сум нь цусанд булагдсан байсан гэж хүмүүс ярьдаг байв. Үүнээс үзэхэд хэн ч Чингис хааны алтан ургийн эрх ашиг, нэр төрд халдвал тэр нум суманд яллуулан шийтгэгддэг гэсэн санаа юм.

#### **ж. “Шангийн өргөө” цагаан ордон**

Шангийн өргөө цагаан ордон нь Чингис хааны цагаан ордны хажууд байдаг. Энэ ордонд алт, мөнгөн эдлэл ба элдэв зүйлийн эртний эдлэл, тахилгын сав хэрэгсэл болон Монголын түүхэн тулгуур бичиг тахилгын тухай судар бичгийг хадгалан мөнх зул өргөн тахиж байдаг. Үүний дотор “цагаан түүх”, “улаан түүх”, “шар түүх” болон хэдэн зүйлийн барлалын “алтан бичиг” байна.

Чингис хааны онгон шүтээний хүрээлэнгийн тогтмол тахилгын газар буй болж бүрэлдсэн дархадын Чингис хааны сүнс шүтээнийг шүтэн тахих тахилга болон бусад зүйлийн тахилгын ёсонд асар их хувирал бий болов. Чингис хааны онгон шүтээний хүрээлэн 1956 онд байгуулагдаж, хэд хэдэн удаа өргөтгөн зассанаар одоо нэн сүрлэг үзэмжтэй болжээ. “Чингис хааны онгон шүтээний хүрээлэнгийн ажиллаж байгаа ерөнхий талбай 1.55 км<sup>2</sup> байж, онгоны ордны эзэлж байгаа талбай 56176 м<sup>2</sup>, онгоны ордны хүрээний эргэн тойрон 840 м” (Ордос, Чингис хааны онгон, 2014.12.09).

1956 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Чингис хааны сүнс шүтээн болон бусад зүйлийн шүтээнийг Хөх нуурын Гүмбэнээс шинэ онгон хүрээлэнд залж авчирсан байв. Мөн ондоо Ордосын хошуудад байсан тахилгын шүтээнийг шинэ онгон хүрээлэнд залж оруулан шүтэн тахив. Энэхүү явдлаас болж зарим уламжлалт тахилга, тахилгын ёс заншил хялбар дөхөм болж өөрчлөгдөв.

### **Ш. Чингис онгоны тахилгын газрын өөрчлөлтүүд**

#### **А. Анх байгуулагдсан үе (1956-1966 он)**

1956 онд “Найман цагаан орд” онгон шүтээн нь хүрээлэнд суурьших болсноос хойш үргэлж

билгийн тооллын 3 дугаар сарын 17-нд “Найман цагаан ордон”-д ёслол хийж, билгийн тоололын 3 дугаар сарын 20-ны өдөр “Найман цагаан ордонд жийглэх” ёслол хийснээс хойш дахиж болоогүй юм. Эдгээр ёс заншил нь өдрийн тахилгын ёслолоор солигдсон байна. Чингис хааны онгон байгуулагдсаны дараа удирдагч Улаанхүү, цэгээ цацлагын тахилгад “алтан гадас”-ыг хүнээр тахиж байсан ёсыг өөрчилж, модоор орлуулах болов. Одоогоор Чингисийн онгонд тусгай алтан гадасын “багана” байна. Шар хасгийн тахилгын ёс нь 1956 оноос хойш тасалдаад байгаа бөгөөд хамгийн сүүлд 3 дугаар сарын 24-ний өдөр найман цагаан ордонд болдог хаврын буцах тахилгын ёс нь тогтмол онгон шүтээний хүрээлэн бий болсноос хойш уг ёсыг хийхээ болив.

#### **В. Соёлын хувьсгалын үе (1966-1976 он)**

Соёлын хувьсгалын үед дөрвөн хуучныг эвдэх чиглэлийн дор 1971 оны өвөл, ӨМӨЗО-ны дайнд бэлтгэх газар Чингис хааны онгоныг дайнд бэлтгэх, давсны хадгаламжийн газар болгов. Давсны хадгаламжийн хэмжээ тухайн тэр үедээ 3000 тн байв. Үүнээс хойш дархадууд шүтээн хүрээлэнгээс хөөгдөн гарч, тахилга үйлдэх нь ч хориглогджээ. Тухайн үед дархадууд тахилгын ёслолыг нууцаар явуулж байсан гэдэг. Энэ хугацаанд Чингис хааны шүтээн ордныг тээж зөөвөрлөж байсан шар хасаг тэрэг эвдэгдсэн байдаг.

#### **С. Өөрчлөлт нээлтийн цаг үе (1975-2002 он)**

Энэхүү үе нь Чингисийн онгоны тахилгын соёл сэргээгдэж байсан цаг болно. 1977 оноос хойш ӨМӨЗО байгуулагдаж, 30,40,50 жилийн ойг тэмдэглэхийн тулд Чингисийн онгоны дотор болон гадна талыг сэргээн засаж, соёл жуулчлалын газар болгон өргөтгөн байгуулж улсын засгийн газраас хэд хэдэн удаа мөнгөн тусламжийг үзүүлжээ. Үүний улмаас Ордосын хошуудад тархаж байсан Дархадын хойч үе Чингисийн онгонд хүрэлцэн ирж тухайн жилийн тахилгын ёсыг эрхлэн хийх болов.

#### **Д. Өргөтгөн байгуулах цаг үе (2002-2015 он)**

Энэ цаг үеэс жуулчлалын газар болгон ашиглахаар Чингисийн онгоныг их хэмжээгээр өргөтгөн байгуулжээ. 2002 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Өвөр Монголын Ардын Засгийн Ордон Чингис хааны онгоныг жуулчлалын газар болгохыг зөвшөөрсний дараа, 2002-2015 оны хооронд уг шүтээн хүрээлэнг хэд хэдэн удаа их хэмжээгээр өргөтгөн зассан байна. Онгон

хүрээлэнг өргөтгөн зассаны дараа 1.55км<sup>2</sup> өргөн уудам тахилгын талбайтай болжээ. Мөн шинэ сүлдийн жийгийг байгуулав. Шинэчлэн зассан онгон шүтээний хүрээлэнгийн гадна барилга 3 хэсгээс бүрэлддэг. Хамгийн түрүүнд нь зочин угтах талбай, үүний ард нь 99 шат бүхий замтай. Энэхүү зам ес есөн шатаар индэрт хуваагдан нийт 99 шатаас бүрэлдсэн байдаг. Чингис хааны үеийн монголчууд бөө мөргөлийн шашины ёсоор мөнх хөх тэнгэрийг шүтэхийн хамт, мөн хөх тэнгэр бол 99 тэнгэрээс бүрэлдсэн гэдэгт итгэдэг байжээ. Чингис хаан “тухайн жил Хэрлэн мөрний хөвөөнд 99 цагаагчин гүүний цэгээгээр мөнх тэнгэрт цацал өргөсөн” юм (Рашпунсаг, 1985).

Энэхүү өргөн дэлгэр ёслол, Чингис хааны онгон шүтээний хүрээлэнгийн хаврын цагаан сүргийн их тахилгаар дамжин одоо болтол уламжлагдан хадгалагдаж ирэв. Монголчууд есийг билэгтэй тоо хэмээн үздэг. Энэхүү шат хэсэг бүртээ 9 шатнаас бүрэлдэнэ. Энэ шат нь Монголчуудын есийн тоог билэгдэлтэй гэдэг заншлыг үндэслэн хийсэн өлзий билэгтэй шат юм. “Өлзий билигт 99 шаттай зам уртаараа 393 метр өргөнөөрөө 12.4 метр өндөр нь 15.3 метр” байдаг (Чингис хааны онгон, 2014.12.09). Хамгийн хойд талд нь 66 метр диаметртэй, төгрөг хэлбэртэй гуулин морины талбай байрлана. Мөн алтан гандир овоо ба цэгээ цацлагын газрыг өргөтгөн засав. Мөн жуулчлалд зориулсан зочин угтах, угтан зочлох газрууд, машины зогсоолтой.

Шинээр байгуулагдсан Чингис хааны онгон шүтээний хүрээлэнгийн барилга өвөрмөц онцгой байдаг. Хэмжээгээрээ өөр гурван бөмбөгөр оройтой, монгол гэр маягийн барилга болно. Дунд нь залгагдсан урт гудамжтай. Төвд нь байрлах голын их ордны ард талд нь ар ордонтой, үүнийг ухрах ордон гэдэг. Энд Чингис хаан болон хатдын сүнс шүтээн, найман цагаан ордны бусад бүрэлдэхүүнийг эрхшүүлэн тахиж байдаг. Эдүгээг болтол дархадууд энэхүү онгон шүтээний хүрээлэнг тогтмол газарт байлган, өөрсдийн үүрэг хариуцлагын дагуу тахилгын таваг тавьж Чингис хааны сүнс шүтээнийг тахин шүтэх үйл ажиллагааг гүйцэтгэсээр иржээ. 2006 онд Чингисийн онгоныг их хэмжээгээр өргөтгөн зассаны дараа цагаан сүргийн тахилга нь он удаан жилийн дараа дахин сэргээгдсэн түүхтэй. Тухайн оны 3 дугаар сарын 17-ны өдөр хар сүлдийг сүлдийн Жийгд залж, эрхшүүлэн тахив.

1956 оноос хойш Чингис хааны тахилга нь нүүдэлт “найман цагаан ордон” байснаа, тогтмол “Чингис хааны онгон шүтээний хүрээлэн” хэмээх газарт шилжив. Энэ нь Чингис хааны тахилгын ордны нэгэн их өөрчлөлт болно. Энэхүү их

өөрчлөлт нь зарим гол тахилгын ёслолын агуулга хэлбэрт өөрчлөлтийг авчирав. Соёлын хувьсгалын үед Чингис хааны онгоныг хадгалан хамгаалагч дархадууд болон тахилгын соёлд ноцтой хохирол учирсан. 1977 оноос хойш Чингисийн онгон сэргээгдэн засагдаж тахилгын соёл сэргээгджээ. Үүний хамт тахилгын газраас гадна найр наадам, хурал цуглаан зэрэг бусад газрууд бий болжээ. **2006 онд, Чингисийн онгон улсын биет бус соёлын өвөөр бүртгэгдэн хамгаалагдав.** 2011 онд улсын хамгийн их жуулчлалын газраар сонгогдов. Онцгойлон 2002 оноос хойш Чингисийн онгоныг хэд хэдэн удаа их хэмжээгээр өргөтгөн байгуулсаны дүнд, Чингис хааны онгоны тахилгын газар нь жуулчлалыг нээн ашиглах, эдийн засгийн нэг урсгалд нөлөөлж байгаа нь гарцаагүй. Гэхдээ энэхүү өөрчлөлт нь дархадын тахилгын соёлыг уламжлал ёсоор хадгалахад зарим саад тотгорыг авчирч байна. Тухайн газрыг хариуцаж буй ажилтаны хэлж байгаагаар, одооны тахилгын ёс нь хуучны тахилгын ёстой хэр төстэй байдлыг харьцуулан үзвэл зууны 20%-аар сэргэж байгаа хэмээжээ (Эрдэнэсүмбэр, 2013.05.03).

Нэгд, Чингис хааны тахилгын газрын өөрчлөлтийн онцлог нь тахилга хийх газар хялбар дөт, давхар цомцог ордоосоо сүрлэг жавхаат орд харштай болсон.

Хоёрт, угийн нүүдэл хэлбэрийн цомцог ордоосоо тогтмол тахилгын онгон шүтээний хүрээлэнтэй болсон. Тэр нь Чингисийн онгон болно. Чингис хааны онгоны тахилгын газрын өөрчлөлт нь Монголчуудын амьдралын хэв маяг, үйлдвэрлэлийн арга хэлбэр, шашин суртахууны соёлын зан заншлын хувиралтай нягт холбоотой байдаг. Монголчууд уугуул шашин бөө мөргөлөө шүтэхийн хамт, бурхны шашныг шүтэх болсон нь Чингис хааны тахилгын газрын өөрчлөлтийн нэг чухал элемент болно. Үүний хамт Чингис хааны тахилгын ордон гэр хийгээд Монголчуудын оршин суурьшиж байгаа байдал нь Монголчуудын амьдралын хэв маягийн өөрчлөлтийг илэрхийлж байдаг. Эдгээрээс үзвэл, Чингис хааны тахилгын мөн чанарт нь зөвхөн хүний оюун ухааны шүтээн биш, нүүдлийн малжих соёл зохих хэмжээгээр хадгалагдаж байдаг.

Нэгтгэн хэлбэл, Чингис хааны онгоны тахилга нь анхны нүүдэлт тахилгын хэлбэрээсээ тогтмол тахилгын газартай болж хувирсан. Энэ нь тахилгын газрын өөрчлөлт мөн. Уг тахилгын газрын өөрчлөлт нь одоогийн Монголчуудын үйлдвэрлэлийн шинж чанар, амьдралын хэв маяг, орчны байдлаас хамаарчээ. Үүний улмаас уламжлалт тахилгын газрын өөрчлөлт нь дархадын уламжлалт тахилгыг уламжлан хадгалахад ихээр

нөлөөлж байна.

Тус өгүүлэл нь БНХАУ-ын улсын нийгмийн шинжлэх ухааны суурь, мөнхийн сэдэв бөгөөд “Биет бус соёлын өв зүйн талын Чингисийн онгоны жуулчлалын соёл” (зөвшөөрсөн дугаар:14CMZ019) судалгааны ажлын нэг хэсэг болно.

### ДҮГНЭЛТ

XVIII зууны эхэн үед янз бүрийн шалтгааны улмаас Чингис хааны тахилгын ихэнх шүтээн нь Баянчунхагын голын Их эзэн хороонд үлдэн тахигдах болсон. Түүнчлэн зарим онцлог шүтээнийг зарим хошуунд эсвэл Дархад нар төвлөрөн сууж байгаа газарт мөн л тахин шүтэж байжээ. 1956 онд Чингис хааны шинэ онгон шүтээний хүрээлэн байгуулагдав. Уг хүрээлэнд онгон шүтээний хүрээлэнг тусгай хамаарах байгууламжийг байгуулж, тусгай ажилтныг оноон томилж онгон шүтээнийг хамгаалах, сахих, тахилга хийхийг хариуцуулав. Чингис хааны найман цагаан ордон болон сүлд нь Ордосын бүх хошуунд хамаарагдаж байсныг Чингис хааны онгонд төвлөрүүлэн шүтээнүүдийг тахиx болсон.

Одоогоор Чингис хааны найман цагаан ордныг Чингисийн онгон хэмээн нэрлэж, нэг газарт хамт орших болсноос хойш Чин улсын үед хошуу болгонд салж бутарсан найман цагаан гэр дахин нийлж, тахилгын ёс нь ч зохицож өөрчлөгдсөн. Энэхүү хувиралт нь Чингисийн онгоны тахилга нь уулын нүүдэлт тахилгын хэлбэрээсээ, тогтсон тахилгын газартай болж өөрчлөгдсөн гэж хэлж болно. Тахилгын газар өөрчлөгдсөн үндсэн шалтгаан нь одоогийн Монголчуудын аж үйлдвэрлэлийн арга хэлбэр, амьдралын орчин ахуйн шинж чанар, хувирлаас шалтгаалжээ. Тахилгын газрын өөрчлөлт нь Дархадын уламжлалт тахилгыг хадгалахад ихээхэн үүргийг гүйцэтгэж байна.

Чингисийн онгоны тахилгын газрын өөрчлөлтийг судлах нь Монгол үндэстний түүх, уламжлалт зан заншил, соёлын судалгаанд үнэ цэнэтэй бөгөөд Монгол судлалын салбар төдийгүй цаашлаад хүн төрөлхтний бодит бус соёлын өвийн судалгаанд чухал ач холбогдолтой юм.

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Рашпунцаг, Т. (1985). Болор эрхи. Хөх хот: Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хороо
- Сайнжаргал. (2001). Монгол тахилга. Хөх хот: Үндэстний хэвлэлийн хороо
- Сайнжаргал., Шаралдай. (1983). “Алтан ордны дайллага”. Хөх хот: Үндэстний хэвлэлийн хороо
- Сурнаа. (2012). “Цагаан сүргийн тахилгын нэршил болон Жийгийн учир соёлын сурвалж” *ӨМИС –ийн эрдэм шинжилгээний сэтгүүл*, 6 дугаар хэвлэл. Хөх хот
- Хурцбаатар, Л., Цогт, О. (2000). “Чингис хааны Алтан бичиг”. Хөх хот: Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо
- Хэрээд., Шаралдай. (2001). Чингис хааны Онгон Шүтээний тайлга тахилга. Хөх хот
- Шаралдай., Нацаг. (2007). Чингис хааны тахилгын соёл. Хөх хот: Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо
- 楊海英. (1998). “金書”研究序說, 国立民族学博物 告7
- 宋濂等撰. (1976). “元史”中 局点校本
- 拉施特. (1985). “史集”第一卷, 第二册, 南印